



WWF

BOOK

MNG

WALKER HAWK



4

УУВРАЛ



WWF

BOOK

MNG



Номын зохиогч: Ю.Санжаагончигийн зохиолоос
сэдэвлэн бүтээв.

Гүйцэтгэгч байгууллага: “Номадик контент” ХХК

Ерөнхий продюсер: Г.Гантуяа
Гүйцэтгэх продюсер: Г.Отгонтуяа
Ерөнхий редактор: Ц.Мөнхжин
Зураачид: Э.Мөнхнаран
Б.Мөнхдөл

Дизайнер: Л.Нандинчимэг
ISBN: 978-9919-9676-0-4

Copyright © WWF

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газар


ДҮРИЙН ТАНИЛЦУУЛГА




За Харангаа хонь ч сайхан
тогтчихлоо нар ч голлочихлоо.



Тэнд харагдаж
байгаа модны
сүүдэрт очъё.












Арай цоохор найз
минь ирчихсэн юм
биш биз.













Жинхэнэ хавх,
нөгөө чимээ
чинь бодит
байжээ.



Ингэхэд
Харанга!! хаана
байна аа...



Харангаа, Харангаа....



Ээ ашгүй, Чамайг аюулд
орчихлоо гэж түгшлээ.





Үдээс хойш...



Хүүгээ амралтаараа ирж байхад нь гадаа, гэргүй гарын үзүүрт зарсаар амралтын хугацаа нь дуусчихлаа. Юу юугүй сургууль орлоо шүү.




Хонь малаа хариулж, аав ээждээ туслан, байгалийн сайханд шогшин явах чинь жинхэнэ амралт юм шүү дээ. Тийм ээ Ууганаа?



Тэр ч, тийм шүү.



Уухайс даа.



Юун хавх вэ?
Хаанаас олов?



Энэ хавханд
Харанга маань
орох шахлаа.



Ээ халаг. Энэ хар төмрийг
хайрхны минь элгэнд булж
амьтан тамлаж байдаг. Үгүй мөн
айхтар улсууд их болжээ.





Харин тийм, Би хэд
хоногийн өмнө бас
нэг хавх олсон.



Ямар хэцүү
хүмүүс вэ?




Багийн хурал дээр
боохой элбэгшлээ гэж
байсан. Тэгээд л хавх
тавьж дээ. Сумын байгаль
хамгаалагчийн ярьснаар
бол эхлээд шинжлэх ухааны
байгууллага судалж тогтоох
ёстой юм гэнэ лээ.



Үнэхээр тоо толгой нь
ихэссэн байвал цөөлөх
арга хэмжээг авдаг
учиртай. Малчид бид
шуудхан хавх тавих нь
зохистой үйлдэл яав ч
биш. Эртээд радиогоор 1
хавх 10 амьтныг хороодог
гээд л ярина лээ шүү.



Хавханд орсон амьтад их зовж дуусдаг
гэсэн. Хөөрхийс, болж өгвөл энэ хар
төмрүүдийг хориглох юм сан даа.
Заримдаа ч малын хөл ороод сүйд
болх юм.



Цоохор минь хавханд орсон байхад нь би олж тусалсан шүү дээ. Өвөө! хөл нь эдгэсэн болов уу?




Хөөрхийс, амьтан гөрөөлж идшилдэг араатан амьтан хавханд хөлөө гэмтээчихээр ямар л өөдтэй байв гэж дээ.



За даа. Харахад эдгэсэн ч хожим уршигтай л болов уу даа. Амьтан гөрөөлж үсэрч, дүүлэх, харайхдаа эмзэг болсон байх вий.



Үсэрч, харайж чадахгүй гэж үү?



Тэгвэл Цоохор найз минь...











Энэ хавх бол маш аюултай зүйл. Амьтад төдийгүй
бидэнд ч аюултай болохыг ойлгосон.









Сумын байгаль хамгаалагч
Пүрэв гэж хүн бий тэр
хүнтэй уулзвал та нарт
туслах болно.



Хурдхан Пүрэв ахтай
уулзахаар явцгаая!



Тэгье




Сайн байна уу? Та. Бид "Сонор" эко-клубийн гишүүд сурагчид байна. Тантай хавхны тухай асуудлаар ярилцахаар ирлээ.



Сайн, сайн байна уу?

Маргааш нь:



Зүгээр дээ, Бид сайн тайлбарлаж чадвал хүмүүс дэмжих байх аа.

Айлууд хавхаа өгөх болов уу? Нуугаад өгөхгүй бол яах вэ?



Сайн байна уу? Сайхан зусаж байна уу. Бид сургуулийн "Сонор" эко-клубийн сурагчид байна. Та бүхнийг "Хавхаа сольё" аянд нэгдээч гэж уриалахаар ирлээ.






Ийнхүү хүүхдүүд малчдад хавхны хор уршиг, амьтдад хэрхэн нөлөөлж буйг цөхрөлгүй тайлбарлаж эхэллээ.



Түрэв ах нь ч хавхаа өгөхгүй байгаа хүмүүст учир байдлыг тайлбарлан тус хүргэсээр байлаа.




Дургүйцэж байсан малчид тэдний тайлбарыг ойлгон хавхаа өгч эхэллээ.





Клубийн сурагчид байгаль хамгаалагч Пүрэв ахын хамтаар машины тэвш дүүрэн хуванцар сав, гялгар уутны хог болон олон тооны хавхнуудыг ачиж явна.





Хүүхдүүд минь, та нар эх орон, ард түмэн, төрөлх нутагтаа ямар үнэ цэнтэй, буянтай ажил хийснээ мэдээж байна уу?



Ах нь та бүхнээрээ их бахархаж байна. Өмнө нь энэ том ажлыг ийм цөөхөн хоногт амжуулснаа мэдэхгүй юм. Та нарын цуглуулсан энэ олон хавх олон амьтдыг, бас тэдний үр төлийг хагацахаас аварч, хамгаалж чадсан гэдэгт итгэлтэй байна.



Манай энэ нутаг лав одоо хавхгүй болсон байхаа.



Гэхдээ бусад багуудын нутгаар өөр хавхнууд булаатай байгааг бид мартаж болохгүй. Та нар энэ удаад өөрсдийн чадах бүхнээ хийлээ. "Оролдлого сайт оройд" гэдэг үг бий. Та нар зэргэлдээ сумын сургуулийн найзуудаа энэ амжилтаа дуулгавал мөн ч их ажил өрнөнө.



Тийм шүү дээ. Цөмөөрөө тэгвэл хөрш сумын хүүхдүүдэд уриалж, өшөө олон хавх устгаж, олон амьтанд жаргалтай амьдрал бэлэглэе.



Яг тийм шүү. Ах нь тэр сумын байгаль хамгаалагчид дуулгаж, та нарт туслах талаар хэлье. Гэхдээ цаг хугацаа нэлээд их шаардах тул тэвчээртэй байх хэрэгтэй шүү. Тэвчээр гэдэг их сайн чанар шүү.



Хэдүүлээ "Хавх булаагүй ууланд хамаг амьтад жаргалтай" гэдэг аян эхлүүлж болно шүү дээ. Манай аав Дэлхийн Байгаль Хамгаалах Санд сайн дурын ажилтан болсон. Аавд хэлэхэд цааш нь дамжуулаад л өгнө. Аавын саналыг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна.



Үгүй ер. Ийм мундаг хүүхдүүд олон байвал амьтнаа хамгаалах ажил ч бэрхшээлгүй болох шинжтэй шүү. Хамгийн том асуудал бол хүмүүс өөрсдөө юм шүү дээ, хүүхдүүд минь. Хавхыг хүн л зохиосон. Гэхдээ тэр үед хүн төрөлхтөн ан агнаж амьдралаа зогоож байсан. Харин одоо тийм үе биш биш тул хавх хэрэггүй болжээ.



Төр засаг маань өргөн уудам, хязгаар нутагтаа хүрч ажиллахаар хичээж буй нэг жишээ бол ах нь өөрөө юм шүү дээ. Бас бидэнд олон улсын байгууллагууд ч тусалж байна. Байгаль дэлхий бүхэлдээ бидний гэр орон, үр хүүхдүүдийн ирээдүй тул хамтдаа хамгаалах хэрэгтэй. Бүх зүйл харилцан шүтэлцээтэй шүү дээ.






Би цоохор найздаа тусалж чадлаа шүү дээ. Бүр түүний олон найзад тусалж, нутгийнхаа шүтээн хайрхныг ч хамгаалж чадлаа.




Ингэхэд цоохор найз минь юу хийж байгаа бол...



Хавх булаагүй ууланд хамаг амьтад жаргалтай





ИРВЭСНИЙ ТУХАЙ СОНИРХОЛТОЙ БАРИМТУУД

01

Мийнхэн шөнийн идэвхтэй мах идэштнүүд. Цоохор ирвэс үдэш, үүр, шөнөөр идэш тэжээлээ хайн гүйнэ. Тиймээс тэр бүр хүнд үзэгдэхгүй нуугдмал амьдралтай амьтан. Тархсан нутагтаа маш сайн зохилдсон тул биеэ сайн далдлан нууна. Ирвэс нэг шөнийн дотор 40 км хүртэл хол замыг туулж чадна.

02

Цоохор ирвэс сэм зөөлхөн явдалтай. Мярааж гэтэж ойртох бөгөөд богино зайд 56-64 км/цаг хурдална. Өргөн тавхай нь цасанд шигдэхгүй, хад чулуугаар зөөлөн, чимээгүй явахад зохилджээ.

03

Дэлхий дээр 36 зүйлийн мий бий. Тэд дэлхийн 6 тивд тархсан бол арслан, бар зэрэг том биетэй мийнүүд 4 тивд тархжээ. Мийнхнийг биеийн хэмжээгээр нь том ба жижиг хэмээн ангилна. Цоохор ирвэс дэлхийн 10 том мийнхний дунд хэмжээгээр 7-8 эрэмбэлэгдэнэ. Харин монгол орны хамгийн том мий бол ирвэс юм.

04

Цоохор ирвэс хар өнгийн толботой, үүлэн саарал зүстэй. Ирвэсийн бодгаль бүрийн биеийн аль нэг хэсэгт онцлог, ялгаатай дахин давтагдашгүй "цоохор" толботой. Түүний нэг нь ирвэсийн духны толбо бөгөөд тэр дахин давтагдашгүй. Монголчууд эртнээс ирвэсийг толбоор нь хавирган цоохор, зоосон цоохор, саран цоохор хэмээн гярхай ажиглан зүсэлдэг байжээ.

05

Цоохор ирвэс үржилд орохоос бусад үед мөнх цастай ян сарьдаг, бартаа саад ихтэй, эгц цавчим тачир ургамалтай өндөр уулсаар ганц, нэгээр амьдарна. Өөрийн эзэмшил нутагтаа эзэн байхын тулд модон дээр маажиж хаяглах, үнэрт шүүрэл хадны хөмөгт үлдээж тэмдэглэх зан төрхтэй.

06

Цоохор ирвэсийн урд мөч бахим богино, хойд мөч, тавхай урт хүчтэй тул тийрч үсрэн харайх, шалмаг түргэн хөдөлгөөнөөр хад бартаат уулсаар хурдан чадамгай дүүлэн гүйнэ. Үүнд хүчилтөрөгчөөр хангаж, агаарыг чөлөөтэй нэвтрүүлэх хамрын өргөн суваг их үүрэгтэй.

07

Цоохор ирвэсийн хөөцөө, нийлэг өвлийн сүүл, хаврын тэргүүн сард эхлэхтэй хамт үдшийн бүрэнхийгээр буйлах, чарлах, бархирах дуу уулсын хөтөл, хавцлаар сонсогдоно. Зуны дунд сард 2-4 гүем гарах бөгөөд дөнгөж төрсөн гүемийн жин 300-700 г хүрнэ.

08

Цоохор ирвэс үүр шөнөөр идшилэхээр гарна. Түүний идэш тэжээлд янгир, аргаль зэрэг туруутан, тарвага, зурам, огдой зэрэг мэргч, хойлог, ахууна, хахилаг зэрэг шувууд оролцоно. Ихэнхдээ янгиргаар идшилнэ. Ирвэсийн идэш тэжээл өвөл, хавар, зунаар ялгаатай. Тархсан нутагт нь гэрийн мал ихтэй газар адуу, хонь, ямаа барьж иднэ.



09

Цоохор ирвэсийн амьдрах орчныг хамгаалж чадвал дэлхийн ундны усны 30%-ийг хамгаалж үлдэж чадна гэдгийг судлаачид тогтоожээ. Ус бол чандмань эрдэнэ. Монгол улсад тусгай хамгаалалтад авсан нийт газар нутгийн 22-т цоохор ирвэс тархаж идээшнэ. Ирвэсийн хамгаалалд түүний идэш тэжээл бологч амьтдыг хамгаалах, тэдний талаар мэдэх нь нэн чухал.

10

Дэлхийн хүн ам өсөж, газар нутгийг ихээр ашиглаж байгаагаас цоохор ирвэс түүний идэш тэжээл бологч амьтдын байршил нутаг, амьдрах орчин улам бүр хомсдож, доройтсоор байна. Бэлчээр доройтсоноор малчин өрхүүд улам бүр уулын өндөрт-ирвэсийн нутагт шахан бууж янгир, аргалийг идээших нутгаас нь дайжуулах болжээ.

10 ялгааг олоорой!



НОМЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Хавхыг хураах нь ямар давуу талтай вэ?

2. Байгаль орчноо хоггүй цэвэр байлгахад чи юу хийж чадах вэ?



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

2015 он

Анх Ховд аймгийн Жаргалант хайрхан ууланд хавханд орсон ирвэсийн дүрс камерт бичигдсэнээс үүдсэн "Хавх булаагүй ууланд хамаг амьтад жаргалтай" аяныг Ховд аймгийн сурагчид эхлүүлжээ.

6 АЙМАГ

Аян Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс аймаг болон нийслэл хотод үргэлжлэн зохион байгуулагдаж бүс нутгаас үндэсний хэмжээний аян болон өргөжжээ.

1434

Эко клубийн хүүхдүүдийн энэ санаачилга оролцоотойгоор эхэлсэн хавх хураах аян 3 жил үргэлжилж нийт 1434 хавхыг цуглуулсан нь байгаль хүрээлэн буй орчинд учруулах олон аюул эрсдэлээс сэргийлж чаджээ.

14,340

Аяны дүнд дэг жилд хамгийн багадаа 14340 амьтны амь аврагджээ. Учир нь нэг хавх хамгийн багадаа 10 амьтныг хороодог болохыг судлаачид тооцжээ.

Энэхүү бүтээл нь Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хэвлэх эрхийг Дэлхийн Байгаль хамгаалах сан эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, өөр бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглах, худалдахыг хориглоно.



Бидний эрхэм зорилго:

Монгол орон зэрлэг ан амьтан, ургамлын өлгий нутаг байж, хүн ард нь байгальтайгаа шүтэлцэн үеийн үед сэтгэл хангалуун амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.



Холбоо барих хаяг:
Утас: +(976)-11-311699
И-мэйл: info@wwf.mn
Facebook: WWF Mongolia